Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны 07 дугаар сарын 01 өдрийн 03/1765 дугаар албан бичгийн хавсралт

# “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, дүнг танилцуулж байна.

**Нэг. Хяналт-шинжилгээний зорилго**

Төлөвлөгөөний гүйцэтгэлийн эхний хагас жилийн явцыг хянах, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөв чиглүүлэх бодлого хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

**Хоёр. Арга зүй**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийхдээ 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Засгийн газрын 43-р тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-т заасан аргачлалаар буюу төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 6.4, 6.5-т заасны дагуу үр дүнг дүгнэсэн.

**Гурав. Хяналт-шинжилгээний үр дүн**

**3.1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2025 оны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт**

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд 26 төсөл арга хэмжээ, Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 16 төсөл арга хэмжээ, Эдийн засгийн бодлогын хүрээнд 134 төсөл арга хэмжээ, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд 27 төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд хөтөлбөрийн эхний хагас жилийн хэрэгжилтийн явц дунджаар **91.2** хувьтай байна.

Дээрх төсөл арга хэмжээг журмын 6.3-т заасны дагуу хэрэгжих хугацаа дууссан, хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа гэж ангилж, дүгнэхэд 203 төсөл арга хэмжээ хэрэгжих хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа гэсэн ангилалд байна.

Хүснэгт 1.Хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ

| Ангилал | Үнэлгээ | Арга хэмжээний тоо | Нийт арга хэмжээнд эзлэх хувь /%/ |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| Үр дүн гарсан | 85% | 160 | 78.8 |
| Үр дүн хүлээгдэж байгаа | 60-84% | 17 | 8.4 |
| Үр дүн хангалтгүй | 30-59% | 15 | 7.4 |
| Үр дүн гараагүй | 0-29% | - | - |
| Хугацаа болоогүй | - | 11 | 5.4 |
| Дүн | | 203 | 100 |

### 3.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

Бодлого үр дүнгийн 11 шалгуур үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн 3 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн үр дүнгийн 6 шалгуур үзүүлэлт нийт 20 шалгуур үзүүлэлт эрхлэх асуудлын хүрээнд батлагдсан.

Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 3 үр дүн тус бүрээр дүгнэхэд 98.3, 60.0, 94.4 хувьтай байна.

Хүснэгт 3.Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт бодлого, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрөөр

| № | Үр дүн | Дундаж |
|---|---|---|
| 1 | Бодлого | 98.3 |
| 2 | ТЕЗ | **60.0** |
| 3 | Хөтөлбөр | 94.4 |

Батлагдсан шалгуур үзүүлэлтэд үр дүн гарсан 12 шалгуур үзүүлэлт, үр дүн хүлээгдэж байгаа 1 шалгуур үзүүлэлт, үр дүн хангалтгүй 1 шалгуур үзүүлэлт, үр дүн гараагүй 0 шалгуур үзүүлэлт, хугацаа болоогүй 6 шалгуур үзүүлэлт байна.

Хүснэгт 4.Шалгуур үзүүлэлтийн үр дүнгийн ангиллаар

| Ангилал | Үнэлгээ | Шалгуур үзүүлэлтийн тоо |
|---|---|---|
| Үр дүн гарсан | 85% | 12 |
| Үр дүн хүлээгдэж байгаа | 60-84% | 1 |
| Үр дүн хангалтгүй | 30-59% | 1 |
| Үр дүн гараагүй | 0-29% | - |
| Хугацаа болоогүй | ХБ | 6 |
| Дүн | | 20 |

## Дөрөв. Дүгнэлт

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан үндсэн 59 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлсэн 144 арга хэмжээг Засгийн газрын 43-р тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.1-т заасан аргачлалын дагуу

дүгнэсэн бөгөөд төсөл арга хэмжээний хэрэгжилт **91.2** хувь, буюу “**үр дүн гарсан**” гэж дүгнэгдлээ.

*Эдийн засаг, хөгжлийн яамны 2025*
*оны 07 дугаар сарын 01 өдрийн 03/1765*
*дугаар албан бичгийн хавсралт*

## “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, дүнг танилцуулж байна.

**Нэг. Хяналт-шинжилгээний зорилго**

Төлөвлөгөөний гүйцэтгэлийн эхний хагас жилийн явцыг хянах, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөв чиглүүлэх бодлого хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

**Хоёр. Арга зүй**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийхдээ 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Засгийн газрын 43-р тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-т заасан аргачлалаар тэргүүлэх чиглэл, төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 6.4, 6.5-т заасны дагуу үр дүнг дүгнэсэн.

**Гурав. Хяналт-шинжилгээний үр дүн**

**3.1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт**

Эдийн засгийн бодлогын хүрээнд 17 төсөл арга хэмжээ, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд 1 төсөл арга хэмжээ, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд 1 төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явц дунджаар **69.9** хувьтай байна.

Дээрх төсөл арга хэмжээг журмын 6.3-т заасны дагуу хэрэгжих хугацаа дууссан, хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа гэж ангилж, дүгнэхэд 19 төсөл арга хэмжээ хэрэгжих хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа гэсэн ангилалд байна.

Төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээнээс 6 арга хэмжээ үр дүнтэй, 6 арга хэмжээ үр дүн хүлээгдэж байгаа, 7 арга хэмжээ үр дүн хангалтгүй гэсэн ангилалд байна.

Хүснэгт 1.Хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүн бодлогоор

| **Бодлого** | | | | | **Нийт** |
|---|---|---|---|---|---|
| | **85%<0** | **60-84%** | **30-59%** | **0-29%** | |
| Эдийн засгийн бодлого | 6 | 5 | 6 | - | 17 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бүчилсэн хөгжлийн бодлого | - | - | 1 | - | 1 |
| Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого | - | 1 | - | - | 1 |
| **Нийт** | **6** | **6** | **7** | **-** | **19** |

Хүснэгт 2.Хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн ангиллаар

| Ангилал | Үнэлгээ | Арга хэмжээний тоо |
|---|---|---|
| Үр дүн гарсан | 85%< | 6 |
| Үр дүн хүлээгдэж байгаа | 60-84% | 6 |
| Үр дүн хангалтгүй | 30-59% | 7 |
| Үр дүн гараагүй | 0-29% | - |
| **Нийт** | | 19 |

**3.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт**

"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний тэргүүлэх чиглэл нь хариуцах байгууллагагүй батлагдсан бөгөөд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 26 тэргүүлэх чиглэлийг Эдийн засаг, хөгжлийн яам тайлагнахаар хуваарилсан. Тус 26 тэргүүлэх чиглэлээс яамны эрхлэх асуудалд хамаарахгүй 9 тэргүүлэх чиглэлийг хасаж 17 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хяналт-шинжилгээ хийсэн. Тэргүүлэх чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилт **74.7** хувьтай байна.

Хүснэгт 3.Тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт үр дүнгийн ангиллаар

| Ангилал | Үнэлгээ | Тэргүүлэх чиглэлийн тоо |
|---|---|---|
| Үр дүн гарсан | 85%< | 8 |
| Үр дүн хүлээгдэж байгаа | 60-84% | 4 |
| Үр дүн хангалтгүй | 30-59% | 5 |
| Үр дүн гараагүй | 0-29% | - |
| **Нийт** | | 17 |

**3.3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт**

Бодлогын үр дүнгийн 3 шалгуур үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн 3 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн үр дүнгийн 11 шалгуур үзүүлэлт нийт 17 шалгуур үзүүлэлт эрхлэх асуудлын хүрээнд батлагдсан.

Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 3 үр дүн тус бүрээр дүгнэхэд 100, 64.5, 68.5 хувьтай байна.

Хүснэгт 3.Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт бодлого, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрөөр

| № | Үр дүн | Дундаж |
|---|---|---|
| 1 | Бодлого | 100.0 |
| 2 | ТЕЗ | 64.5 |
| 3 | Хөтөлбөр | 68.5 |

**Дөрөв. Дүгнэлт**

"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, тэргүүлэх чиглэлийг Засгийн газрын 43-р тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.1-т заасан аргачлалын дагуу дүгнэсэн бөгөөд төсөл арга хэмжээний хэрэгжилт **69.9** хувь, тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт **74.7** хувьтай буюу хэрэгжилтийн явц зорилтот түвшний **"үр дүн хүлээгдэж байгаа"** гэж дүгнэгдлээ.

**Тав. Зөвлөмж**

Төлөвлөлтийг оновчтой болгох талаар:

1.Салбарын чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүний хүрэх үр дүнг төлөвлөхдөө урьдчилсан судалгаа, үнэлгээг хийж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, шат дараалал, хэрэгжих хугацаа, гарах үр дүн, өмнөх жилийн гүйцэтгэл, тулгарсан асуудал зэргийг нарийвчлан судалж, төсөл, арга хэмжээ болон түүний хүрэх түвшинг оновчтой төлөвлөх;

2. Төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл, арга хэмжээг боловсруулахад үндсэн болон хамтрагч байгууллагууд идэвх санаачилгатай оролцож, хамтран ажиллах хүрээ, хязгаарыг нарийн тохирох.

Тайлагналтыг сайжруулах талаар:

1. Дотоод бүтцийн нэгжүүд **med.igovernment.mn-д** заасан хугацаанд тайлагнаж хэвших;
2. Тухайн арга хэмжээний хүрээнд бодит гарсан үр дүн, хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, холбогдон гарсан санхүүжилтийн гүйцэтгэл зэргийг иж бүрэн тайлагнаж, тайлагналын чанар стандартыг хангах;
3. Бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тайлагнах чиг үүрэгтэй албан хаагчид хариуцлагатай хандаж, нэгжүүд харилцан уялдаатай байж, журамд заасан цаг хугацааг баримтлах.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны 07 дугаар сарын 01 өдрийн 03/1765 дугаар албан бичгийн хавсралт

**Засгийн газрын 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр**

| Д/д | Зорилго | Зорилт | Төсөл, арга хэмжээ | Гүйцэтгэлийн хувь | Өссөн дүн | Хэрэгжилт | Батлагдсан төсөв | Батлагдсан эх үүсвэр | Санхүүжилтийн гүйцэтгэл | Санхүүжилтийн эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | | |
| 1.1. Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт | | | | | | | | | | | | | | | | | |
| | 1.1.2. Эрчим хүчээр хангагдсан хот | 1.1.2.3. Хүрэн нүүрсний ордыг түшиглэсэн 300 МВт-ын хүчин чадал бүхий дулааны цахилгаан станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна. | 9. Бөөрөлжүүтийн 300 МВт-ын цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах | 100% | 100% | Төслийн барилга угсралтын ажил 2022 оны 07 дугаар сараас эхэлсэн ба станцын эхний 150 МВт-ын блокыг 2024 оны 10 дугаар сард, хоёр дах 150 МВт-ын блокыг 2025 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар төслийн талбайд нийт 800 ажилчид, 45 машин механизм ажиллаж байгаа бөгөөд зуух, станцын үндсэн барилгын ган карказ угсралтын ажил болон дагалдах барилгын суурийн ажил, дэд бүтцийн ажлууд хийгдэж байна. Төслийн ерөнхий барилга угсралтын ажил үргэлжилж байгаа бөгөөд ЭХЯ-аас сар бүр хэрэгжилтийг гаргуулан авч, хяналт тавин ажиллаж байна. | | 0 | 0 | Улсын төсөв | | | | | | | |
| | | 1.1.2.4. Хог шатаах аргаар эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг дэмжинэ. | 10. 15-20 МВт-ын хүчин чадалтай хог шатаах үйлдвэр байгуулах | 100% | 100% | Улаанбаатар хотын Морингийн даваа болон Цагаан давааны хог хаягдлын төвлөрсөн цэгүүд дээр тус бүр 24 МВт хүчин чадалтай хог шатаах үйлдвэр байгуулах төсөл эхлээд байна. Энэхүү төсөл нь өдөрт дунджаар 500–700 тонн хог хаягдлыг боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, ингэснээр хог хаягдлыг шууд булшлах практикийг үе шаттайгаар халж, байгаль орчны доройтол болон эрчим хүчний хомсдолыг бууруулах чухал зорилттой уялдаж байна. 2021–2024 оны хооронд төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, олон улсын туршлагыг судлах, боломжит хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулах ажлууд хийгдсэн. Үүнд Япон, Хятад, Солонгос зэрэг улс орнуудын технологи, мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан бөгөөд TianYing Group (БНХАУ) зэрэг компаниудтай уулзалт, санал солилцсон бөгөөд хамгийн сүүлд, 2025 оны 3-р сард Морингийн даваанд байгуулагдах хог шатаах үйлдвэрийн барилга угсралтын тендер зарлагдаж, төслийн хэрэгжилтийн ажил албан ёсоор эхэлсэн. | | 0 | 0 | Улсын төсөв | | | | | | | |
| | | 1.1.2.6. Дулааны II цахилгаан станц, Дулааны III цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлнэ. | 16. Дулааны III цахилгаан станцын 300 МВт-ын өргөтгөл, шинэчлэлийн төслийг хэрэгжүүлэх | 100% | 100% | Эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй, | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.1.2.9. Дулааны IV цахилгаан станцыг 500 тонн/цагийн уур үйлдвэрлэх хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөнө. | 19. Дулааны IV цахилгаан станцыг 500 тонн/цагийн уур үйлдвэрлэх хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх | 100% | 100% | Эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй. | | 0 | 0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт | 1.1.3.5. Гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад орон сууц барьсан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх бодлого баримтална. | 36. Гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад орон сууц барих аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | 1. Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилт, хувь | хувь | 2023 | | 100 | | Х.Б |
| | 1.1.5. Олон төрөлт нийтийн тээвэр, авто зам | 1.1.5.2. Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламж барина. | 62. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4, 23 дугаар хороо, Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох авто замын Наадамчдын гудамжны авто зам дээгүүр шинээр гүүрэн байгууламж барих | 100% | 100% | ЭЗХС-ын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.1.5.3. Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км "Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1", Ард Аюушийн өргөн чөлөө-Их тойруу-Намъянжүгийн гудамж-Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урт тусгай замын автобус "BRT Шугам-1", Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт "Дүүжин тээвэр шугам-1" бүхий олон төрөлт их багтаамжийн нийтийн тээврийн системүүдийн уялдаа холбоог хангаж, зорчигч тээврийн логистик төвийн хамт үе шаттайгаар барьж байгуулна. | 66. Улаанбаатар хотод Хөнгөн галт тэрэг (Трамвай шугам) нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХЯ-ын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.1.5.4. Олон улсын чанартай 88 км "Шинэ тойрог зам", Туулын хурдны авто замыг барьж, ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулна. | 67. Шинэ тойрог зам төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Туул голын дагуух хурдны замыг барих | 100% | 100% | ЭЗХЯ-ын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 68. Шинэ тойрог зам төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто замыг барих | 100% | 100% | ЭЗХЯ-ын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| 1.2. Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2.1. Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын дэд бүтэц | 1.2.1.2. Аялал жуулчлал, тээвэр, логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Шинэ Зуунмод дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна. | 75. "Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадавхтай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл"-ийг хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | 1.2.2. Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын хөгжил | 1.2.2.5. Шинэ Зуунмод хот дахь чөлөөт бүсийг түлгүүрлан "Цахиурын хөндий", дата төв, хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ. | 90. Шинэ Зуунмод хот дахь чөлөөт бүсийг түлгүүрлан "Цахиурын хөндий", дата төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.2.2.7. Олон улсын санхүүгийн төв байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 95. Шинэ Зуунмод хот дахь чөлөөт бүсийг түлгүүрлан олон улсын санхүүгийн төв байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангах | 100% | 100% | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д зааснаар чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудал тул Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл" нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас Онцгой байдал, бүсчилсэн хөгжлийн асуудал эрхэлсэн Шадар сайдын ажлын алба руу шилжсэн. Иймд арга хэмжээний хэрэгжилтийг Шадар сайдын ажлын албанаас гаргах нь зүйтэй байна. | | 0 | 0 | | | | | | | | |
| 1.3. Бүсийн төрөлжсөн хөгжил | | | | | | | | | | | | | | | | | |
| | 1.3.1. Хангайн бүс - "Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс" | 1.3.1.3. Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх, соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд түлгүүрласан "Төв Азийн түүх, соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна. | 98. Архангай аймгийн Өгийнуур, Хотонт, Батцэнгэл, Ихтамир, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Хайрхан сумдын нутагт орших археологийн дурсгалд түлгүүрласан цогцолбор байгуулах | 90% | 90% | Тус төслийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх тохиолдолд ТХХТ-ийн тухай хууль болон "Бүрэн шинжилгээ хийх журам"-д заасны дагуу тухайн асуудал хариуцсан салбар яамны зүгээс түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг холбогдох тооцоолол, мэдээллийн хамт ирүүлэх ёстой бөгөөд одоогоор салбар яамдаас санал ирээгүй болно. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс холбогдох сайд нарт "Төслийн санал ирүүлэх тухай" 2024 оны 01/1891 дугаар албан бичгийг хүргүүлсэн боловч тус төслийн санал мөн ирээгүй болно. Улмаар 2025 оны 01 дүгээр 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар ЭЗХЯ-ны зүгээс Монгол Улсын богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулж, тус өдрийн Засгийн газрын хуралдааны 2 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Үүний хүрээнд мөн 2025 оны "Төслийн санал ирүүлэх тухай" 01/271 дугаар албан бичгийг холбогдох сайд нарт хүргүүлсэн болно. | | 0 | 1 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 99. Орхон голын сав, Хангайн нуруун экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх соёлын, | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.3.1.5. Байдрагийн усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ. | 102. Байдрагийн усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх | 50% | 50% | "Эрчим хүчний сайдаас 2025 оны а/391 дугаар албан бичгээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх "Байдрагийн усан цахилгаан станц" төслийн саналыг ирүүлсэн.<br>Тухайн төслийн урьдчилсан үнэлгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон Эрчим хүчний яам хамтран хийж, түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой санал, дүгнэлт гаргасан.<br>Үүний дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/120 дугаар тушаалаар тухайн төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийг байгуулсан бөгөөд төслийн бүрэн шинжилгээг хийж байна." | | 0 | 0 | | | | | | | | |
| | 1.3.2. Баруун бүс - "Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс" | 1.3.2.3. Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк, эрдэс, түүхий эдийн нөөцөд түлгуурлан дэвшилтэт технологийн шохойн үйлдвэр, Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулахыг төр, хувийн хэвшлийн хүрээнд хамтран хэрэгжүүлнэ. | 105. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээг хийж, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулж, парк, цогцолборын үйл ажиллагааг эхлүүлэх | 90% | 90% | Тус төслийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх тохиолдолд ТХХТ-ийн тухай хууль болон "Бүрэн шинжилгээ хийх журам"-д заасны дагуу тухайн асуудал хариуцсан салбар яамны зүгээс түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг холбогдох тооцоолол, мэдээллийн хамт ирүүлэх ёстой бөгөөд одоогоор салбар яамдаас санал ирээгүй болно. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс холбогдох сайд нарт "Төслийн санал ирүүлэх тухай" 2024 оны 01/1891 дугаар албан бичгийг хүргүүлсэн боловч тус төслийн санал мөн ирээгүй болно. Улмаар 2025 оны 01 дүгээр 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар ЭЗХЯ-ны зүгээс Монгол Улсын богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулж, тус өдрийн Засгийн газрын хуралдааны 2 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Үүний хүрээнд мөн 2025 оны "Төслийн санал ирүүлэх тухай" 01/271 дугаар албан бичгийг холбогдох сайд нарт хүргүүлсэн болно. | | 0 | 0 | | 1. Ажлын гүйцэтгэл, хувь | хувь | 2023 | | 5 Төсөв: 6000 | 0 | 0.00% |
| | | 1.3.2.4. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төсөл, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг хэрэгжүүлнэ. | 106. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 107. Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км урт ЦДАШ-ыг барих төслийг хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 108. Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжих дамжуулах шугамын төсөл "Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 399 км урт ЦДАШ, болон "Мянгад", "Улиастай" дэд станцуудыг барих төсөл"-ийг хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | 1.3.3. Хойд бүс- "Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс" | 1.3.3.2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна | 111. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол, технологийн түвшний үнэлгээ хийх, үндсэн болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулж, батлуулах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулна. | 112. Үйлдвэрийн үндсэн барилга, байгууламж, агуулах барих болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.3.3.3. Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина. | 113. "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн "Байгал нуур"-т үзүүлэх олон талт нөлөөллийн судалгааг Дэлхийн өвийн хорооны аргачлалд нийцүүлэн боловсруулах, Оросын Холбооны Улсын талтай нэгдсэн ойлголцолд хүрэх | 80% | 80% | "Эгийн голын УЦС төслийн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Монгол-Оросын экспертийн ажлын хэсэг" анхдугаар хуралдааныг 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Москва хотноо ОХУ-ын Шинжлэх ухааны академийн байранд зохион байгуулж, "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 172 дугаар тогтоол, БОУАӨЯам, ШУА-тай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг 2025.05.02-ны өдөр, "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны I үе шатны ажлын даалгаврыг 2025.05.08-ны өдөр, Юнеско-ийн Дэлхийн өвийн хорооны аргачлалын дагуу боловсруулах "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг 2025.06.06-ны өдөр батлан тендерийг зарласан.<br>Эгийн голын УЦС төслийн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Орос-Монголын хамтарсан экспертийн хамтарсан ажлын хэсгийн урьдчилсан ээлжит бус хурал 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдөр ОХУ-ын Эрхүү хотын ШУА-ийн, Сибирийн салбарын В.М. Матросовын нэрэмжит Системийн динамик, удирдлагын онолын хүрээлэнгийн хурлын танхимд зохион байгуулж, Монголын талын экспертийн ажлын хэсгийн боловсруулсан "Эгийн голын УЦС" төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажлын даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх, Орос-Монголын хамтарсан экспертийн хамтарсан ажлын хэсгийн ээлжит хоёрдугаар хурлыг 7 дугаар сард Монгол Улсад зохион байгуулахаар тохиролцсон. | | 0 | 5500000 | Улсын төсөв | | | | | | | |
| | 1.3.4. Говийн бүс - "Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс" | 1.3.4.1. "Тавантолгой" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Кокс-химийн цогцолбор барих ажлыг эхлүүлнэ. | 117. Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрийн үндсэн зураг төсөв, технологийн түвшний үнэлгээ боловсруулж, батлуулах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 1.3.4.6. Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина. | 127. Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.3.5. Төвийн бүс- "Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс" | 1.3.5.1. Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолбор, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжин хөгжүүлнэ. | 128. "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн 1 дүгээр үе шатыг хэрэгжүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | 1. Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилт, хувь | хувь | 2023 | | 100 | 100 | 100.00% |
| 1.4. Орон нутгийн хөгжил | | | | | | | | | | | | | | | | | |
| | 1.4.1. Шилжилт хөдөлгөөн | 1.4.1.8. Аймаг, нийслэл, сумын хот байгуулалтын баримт бичгийг бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. | 147. Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж, батлуулах | 85% | 85% | ЭЗХЯ, ХББОСЯ, Орхон аймгийн ЗДТГ-ын оролцоотой хамтарсан ажлын хэсэгт ажиллаж, санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. | | 0 | 0 | | | | | | | | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | | |
| 2.1. Чинээлэг Монгол хүн | | | | | | | | | | | | | | | | | |
| | 2.1.2. Хөдөлмөр эрхлэлт | 2.1.2.5. Гадаадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийг эх орондоо эргэн суурьшихад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлнэ. | 232. Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол Улсын иргэдэд чиглэсэн цогц хөтөлбөр хэрэгжүүлэх | 90% | 90% | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд "Дэлхийн Монголчууд II" цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,. "Монгол Үндэстний үнэлэмж" цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зэрэг Монгол Улсын иргэдэд чиглэсэн цогц хөтөлбөрүүдийн төсөл арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 2.1.2.6. Ядуурал, ажилгүйдэл болон хүн амын амьжиргааны түвшинийг тооцох аргачлалыг үндэсний онцлогт нийцүүлж, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилан шинэчилнэ. | 233. Салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, шаардлагатай мэдээллийн сан бий болгох үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах | 90% | 90% | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө" гэж заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах журам боловсруулах болон холбогдох судалгааг хийхээр ЭЗХЯ-ны 2025 оны төлөвлөгөөнд тодорхой хэмжээний санхүүжилтыг тусган, зөвлөх үйлчилгээний тендер зарлахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | | 0 | 0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 234. Өрхийн амьжиргааны түвшнийг тооцох аргачлалд үндэслэсэн ядуурал, ажилгүйдэл, амьжиргааны түвшний шинжилгээнд зориулсан хосолмол аргачлал нэвтрүүлэх | 100% | 100% | Олон хэмжээст ядуурлын үзүүлэлтүүдийг тодорхойлох, тооцооны арга зүйг боловсруулах тухай ҮСХ-ны даргын 2025 06-ны 10-ны өдрийн А/72 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хамтран ажиллаж байна. Монгол Улсыг хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийн 1 дүгээр хавсралтын Хүний хөгжлийн бодлого бүлэгт "тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлж, "Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг баримтлан, хүн бүрд саадгүй, хүртээмжтэй, аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлж, ядуурал, тэгш бус байдлыг бодитой бууруулж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ" гэж, 2.3.1-т "Гэр бүлд ээлтэй, хүн төвтэй, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээний тогтолцооны цогц шинэчлэл хийж, их өгөгдөл, хиймэл оюуныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг үе шаттай нэвтрүүлнэ" гэж тус тус тусгасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцэн баталсан. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 235. Нийгмийн халамж хүртэх зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг шинэчилж, зорилтот өрхийн амьжиргааны түвшнийг үнэлэх судалгаа хийх | 100% | 100% | Монгол Улсыг хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд Хүний хөгжлийн бодлого бүлэгт "тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлж, "Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг баримтлан, хүн бүрд саадгүй, хүртээмжтэй, аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлж, ядуурал, тэгш бус байдлыг бодитой бууруулж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ" гэж, 2.3.2-т "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ" гэж тус тус тусгасан. | | 0 | 0 | Улсын төсөв | | | | | | | |
| | 2.1.3. Нийгмийн баталгаа | 2.1.3.8. Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална. | 260. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | 90% | 90% | Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох материалыг судлан үзэж 2025 оны 01/1555 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн болно. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 2.1.3.9. Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ. | 264. Эх, хүүхдийг дэмжихэд чиглэсэн тэтгэмж, тусламжийг нийгмийн халамжийн бодлогоос зааглаж, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгаж, | 100% | 100% | "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-нд Гэр бүлд ээлтэй, хүн төвтэй, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээний тогтолцооны цогц шинэчлэл хийж, их өгөгдөл, хиймэл оюуныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг үе шаттай нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг тусгасан. | | 0 | 0 | Улсын төсөв | | | | | | | |
| | | 2.1.3.14. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлнэ. | 274. Бизнес инкубаторын үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| 2.2. Эрдэм боловсролтой монгол хүн | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.1. Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол | 2.2.1.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ. | 306. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн салбар дундын систем хөгжүүлж, нэвтрүүлэх | 85% | 85% | "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-нд Мэргэжлийн болон техникийн боловсролд эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжилтэй уялдуулан хосмог ажлын байрны сургалтыг нэвтрүүлэх арга хэмжээг тусгасан. | | 0 | 0 | Улсын төсөв | | | | | | | |
| | 2.2.2. Мэдлэг чадвартай мэргэжилтэн | 2.2.2.4. Төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шатлалсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлнэ. | 348. Дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, хотхоныг төрөлжүүлэн хөгжүүлэх | 85% | 85% | "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-нд Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх төсөл, арга хэмжээг тусгасан. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 2.2.2.7. Төрийн өмчийн их сургуулиудыг сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болгон хөгжүүлж, академик эрх чөлөөг хангаж, инновацын экосистемийг бүрдүүлнэ. | 354. Судалгааны их сургууль байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, судалгааны их сургуулийг байгуулах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 355. Төрийн өмчийн их сургууль, харьяа хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлж ажиллах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| 2.3. Эрүүл Монгол хүн | | | | | | | | | | | | | | | | | |
| | 2.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж | 2.3.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/. | 402. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв барих | 90% | 90% | 2024 оны 10 сарын 18-ны өдрийн Монгол Улсын Их хурлын 35 дугаар тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан. Төлөвлөгөөний 3.1.2.2-д Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийг барих" гэж туссан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн батлуулсан. Төлөвлөгөөний "2.1.1.1.Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв барих" гэж туссан. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 404. Халдварт өвчин судлалын үндэсний төв-2 байгуулах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | | | 405. Зүрх судасны үндэсний төв байгуулах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| 2.4. Баялагтай эзэн монгол хүн | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.4.2. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл | 2.4.2.4. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх гол нэр төрлийн материал болох ган туйван, цемент, хавтгай шилийг эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэж, импортыг бууруулна. | 449. Эх орны эрдэс түүхий эд /шохойн чулуу/-ээр дотооддоо үйлдвэрлэж буй цемент, шохойн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжиж, үйлдвэрлэлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх | 90% | 90% | Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн "3.1.2.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ." гэж батлагдсан. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 2.4.2.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 452. Цементийн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжийг дэмжих | 90% | 90% | Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн "3.1.2.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ." гэж батлагдсан. | | 0 | 0 | | | | | | | | |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | | |
| 3.1. Эдийн засгийн эрх чөлөө | | | | | | | | | | | | | | | | | |
| | 3.1.1. Макро эдийн засгийн тогтвортой байдал | 3.1.1.1. Эдийн засгийн өсөлтийг жил бүр 6 ба түүнээс дээш хувьд тогтвортой байлгах, инфляцыг 5 хувиас бага түвшинд хадгалах бодлогыг баримталж, гадаад валютын нөөцийг 10 тэрбум ам.доллар хүртэл нэмэгдүүлнэ. | 472. Эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш хадгалах бодлогыг баримтлах | 90% | 90% | Дотоодын нийт бүтээгдэхүүн 2025 оны эхний улиралд нэрлэсэн дүнгээр 18.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, бодит дүнгээр 6.2 их наяд төгрөг хүрснээр эдийн засаг 2.4 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн эрчим саарлаа. Үйлчилгээний салбарууд болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдаа, барилга, цэвэр татвар зэрэг салбарууд агшиж, өсөлтийг саарууллав. Уул уурхайн салбар өмнөх оны мөн үед 13 хувиар өсөж байсан бол 2025 оны эхний улирал зэсийн баяжмал үйлдвэрлэлээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаар тус салбарын өсөлт 0.8 хувьд хязгаарлагдав. Уул уурхайн бус салбар 2024 оны эхний улиралд 7.0 хувиар өсөж байсан бол 2025 оны эхний улиралд 2.3 хувиар өсөөд байна. Уул уурхайн бус салбарын өсөлт саарахад тээврийн салбарын уналт гол нөлөөлсөн бөгөөд тээврээс бусад уул уурхайн бус салбарын өсөлт 4.3 хувь гарсан байна. Тээврийн салбарын агшилтад тээсэн ачаа тээврийн хэмжээ 1 хувиар буурснаас гадна уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, тээврийн өртгийг бууруулах ажлын хүрээнд хийгдсэн төмөр замын суурь бүтэц ашиглалтын тарифыг 50 хүртэлх хувиар хөнгөлөх, мөн авто тээврийн тарифыг бууруулах шийдвэрүүд голлон нөлөөллөө. 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар 2.4 хувь болж саарсан эдийн засаг Үндэсний статистикийн хорооны 2025 оны эхний 4 сарын эдийн засгийн өсөлтийн туршилтын тооцоогоор 4.9 хувиар өсөж, өсөлтийн эрчим нэмэгдлээ. Уг өсөлтийн 4.1 нэгж хувийг хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарууд бүрдүүлсэн байна. | | 0 | 0 | | 1. Эдийн засгийн өсөлт, хувь | хувь | 2023 | 6 | 8 | 2.4 | 90.00% |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 473. Инфляцыг 5 хувиас бага түвшинд хадгалах бодлогыг баримтлах | 100% | 100% | Инфляц 2025 оны 4 дүгээр сард 8.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар эрчимжсэн бол өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурсан байна. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд цахилгааны тарифын өөрчлөлт болон өмнөх жилийн малын зүй бус хорогдлын нөлөөгөөр махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өссөн нь голлон нөлөөлөв. Тодруулбал, цахилгааны тарифын шинэчлэл инфляцыг 1.2 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн байна. Мөн мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар өсөж, инфляцын 1.2 нэгж хувийг дангаар бүрдүүлсэн байна. Мөн түүнчлэн, 2025 оны 2 дугаар сард автобусны үнэ 100 хувиар өссөнөөр инфляцыг 0.4 нэгж хувиар өсгөх нөлөө үзүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яам инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулахад бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, худалдааны сүвгийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг хязгаарлах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. | | 0 | 0 | | 1. Инфляцын түвшин, хувь | хувь | 2023 | 8 | 7.2 | 8.6 | 100.00% |
| | | | 474. Гадаад валютын нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх бодлогыг баримтлах | 100% | 100% | Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 онд 80 их наяд төгрөгт хүрснээр нэг хүнд ногдох ДНБ 2024 онд 6,890 ам.доллар хүрсэн бол гадаад валютын албан нөөц 2025 оны 5 дугаар сарын байдлаар 5193.7 сая ам.долларт хүрч нэмэгдлээ. Эдийн засаг, хөгжлийн яам нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, эдийн засгийг төрөлжүүлэх, инфляцын өсөлтийг хязгаарлах, экспорт, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, төгрөгийн ханшийг савлагаагаар бууруулах бодлогыг баримтлан ажиллаж байна. | | 0 | 0 | | 1. Гадаад валютын улсын нөөц, тэрбум ам.доллар | тэрбум ам.доллар | 2023 | 4.9 | 5 | 5 | 100.00% |
| | | 3.1.1.2. Төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангана. | 475. Тухайн жилийн төсвийн урсгал зардлын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын хувь хэмжээнд нийцүүлэн төлөвлөх | 100% | 100% | Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх төсвийн тусгай шаардлагыг баримтлан, Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24 хувь, 2027 онд 23 хувь, 2028 онд 22 хувьтай байхаар үе шаттайгаар бууруулж тооцсон. Улмаар тус хуулийн төслийг 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн батлаад байна. | | 0 | 0 | | | | | | | | |
| | | 3.1.1.3. Байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, Ирээдүйн өв санд ирээдүй үедээ хуримтлал үүсгэж, зээлжих зэрэглэл өндөртэй Засгийн газруудын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, Хөгжлийн сангаар улсын эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх томоохон төслүүдийг санхүүжүүлнэ. | 478. Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх | 100% | 100% | Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зориулалттай Хуримтлалын сангаас иргэдэд орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд ГБХНХЯ-аас боловсруулсан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгаас 2025 оны төсвийн жилд Хуримтлалын санд хуульд заасны дагуу төвлөрүүлэхийг орлого, Хуримтлалын санд 2025 онд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор холбогдох гэрээ байгуулж ажиллахыг үүрэг болгосон Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах тухай албан бичиг ирүүлсэн. Үүний хариуд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу хуримтлалын сангийн эх үүсвэрийг иргэн бүрд тэгш, хүртээмжтэй байлгах бодлогыг баримталж, орон сууц, эрүүл мэнд болон боловсролын зориулалтаар дэмжлэг үзүүлэхэд чиглүүлэх агуулга бүхий 2025 оны 01/1199 тоот албан бичгийг боловсруулан хүргүүлсэн болно. | | 0 | 0 | Улсын төсөв | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1.2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа | 3.1.2.1. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зохицуулалтыг хялбарчлан, салбаруудын болон хувийн хэвшлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ. | 480. Зах зээлийн төвлөрөл болон зах зээлд нэвтрэх саадыг бууруулах арга хэмжээ авах | 100% | 100% | ЭЗХ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй | | 0 | 0 | | | | | | | | |
| | 3.1.3. Банк, санхүү, даатгалын салбарын шинэчлэл | 3.1.3.1. Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ. | 488. Банк санхүүгийн болон даатгалын салбарын шинэчлэлийн бодлогыг боловсруулах замаар гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх орчныг сайжруулах | 90% | 90% | "Шадар сайд Х.Доржхандын 2024.10.25-ны өдрийн 09 тоот тушаалаар холбогдох яам, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжилтэн, хөндлөнгийн судлаачдын төлөөллүүдийг оролцуулсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын гишүүдийн саналыг тусгасан бөгөөд үзэл баримтлалыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран 2024 оны 12 сард баталсан.<br>Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.04.18-ны өдрийн А/50 болон Монгол Улсын Шадар сайдын 33 дугаар хамтарсан тушаалаар ""Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах"" чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 2025.05.09-ний өдөр олон нийтээр хэлэлцүүлэн, хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Улмаар төслийг 2025.06.04-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу бэлтгэл ажлыг хангаж байна." | | 0 | 0 | | 1. Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилт, хувь | хувь | 2023 | | 100 Төсөв: 200 | 90 | 90.00% |
| | | 3.1.3.3. Банкны салбарын шинэчлэлийг үргэлжлүүлнэ. | 490. Банкны салбарын шинэчлэлийг үргэлжлүүлэх | 100% | 100% | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолыг боловсруулж батлуулах хүрээнд банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан тус тогтоолын 17-д "Гадаадын банкны салбар Монгол Улсад байгуулагдах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, холбогдох журмын шалгуурыг хөнгөвчлөх талаар хамтран ажиллаж, банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх" тухай тусгасан. Үүний дагуу Монголбанкнаас "Гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам"-ыг шинэчилж зарим хатуу шаардлагуудыг хүчингүй болгосон. Түүнчлэн гадаадын банк бодитоор оруулж ирэхэд идэвхтэй хөөцөлдөж, боломжит хөрөнгө оруулагч нарыг урьж, нөхцөл байдлыг танилцуулж ажиллах, ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ЗГ-аас Монголбанканд тодорхой зөвлөмж хүргүүлсэн. Энэ хүрээнд Монголбанкнаас гадаадын банкны салбар нэгжийг дотоодын зах зээлд нэмэгдүүлэх чиглэлээр "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл"-д "2.1. Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг орчныг бүрдүүлнэ" гэсэн заалтыг тусган эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ажиллаж байна. | | 0 | 0 | | 1. Арга хэмжээний хэрэгжилт, хувь | хувь | 2023 | | 40 | | Х.Б |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
